

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/07.

Арвайхээр сум

Эмнэлгийн нөхцөлд эндсэн 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийг магадлан хэлэлцэх зөвлөлийн бүрэлдэхүүн томилох тухай

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 06-ний өдрийн “Эмнэлгийн нөхцөлд эндсэн 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийг магадлан хэлэлцэх тухай” А/263 дугаар тушаалыг тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эмнэлгийн нөхцөлд эндсэн 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийг магадлан хэлэлцэх журам"-ыг нэгдүгээр, “Магадлан хэлэлцэх зөвлөлийн бүрэлдэхүүн, гүйцэтгэх үүрэг”-ийг хоёрдугаар, “Хүүхдийн цогцсыг эмгэг судлалын шинжилгээнд оруулах журам”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Журмын хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар ханган ажиллахыг Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга (Ю.Ичинноров)-д даалгасугай.

3.Тушаалыг мөрдөж ажиллахыг төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгуулагуудын захирал, дарга нарт үүрэг болгосугай.

4.Магадлан хэлэлцэх хурлаас гарсан шийдвэрийн гүйцэтгэлд хяналт тавьж, зохион байгуулалтаар ханган ажиллахыг Удирдлага төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Оюунтуяа), Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтсийн дарга (Я.Жаргал) нарт тус тус даалгасугай.

5.Энэхүү тушаал гарсантай холбоотойгоор Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн “Эмнэлгийн болон эмнэлгийн бус нөхцөлд эндсэн тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийг магадлан хэлэлцэх тухай” А/45 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д.ШИВААННҮРДЭВ

622301033

Эрүүл мэндийн газрын даргын
2023 оны .03 дугаар сарын .14.-ны
өдрийн 407 дугаар тушаалын
Нэгдүгээр хавсралт



ЭМНЭЛГИЙН НӨХЦӨЛД ЭНДСЭН 5 ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, АМЬГҮЙ ТӨРӨЛТИЙГ МАГАДЛАН ХЭЛЭЛЦЭХ ЖУРАМ

Нэг. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Хүүхдийн эндэгдлийг магадлан хэлэлцэх зөвлөлийн хурал нь эмнэлгийн нөхцөлд эндсэн 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийг хэлэлцэн, үнэлэлт, дүгнэлт өгөх үйл ажиллагаа юм.

Хоёр. ЗОРИЛГО

Магадлан хэлэлцэх зөвлөлийн хурал нь эмнэлгийн нөхцөлд эндсэн 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтөд нөлөөлсөн шалтгааныг магадлан хэлэлцэж, дүн шинжилгээ хийж, алдаа дутагдлыг давтагдахаас сэргийлэх, цаашид авах арга хэмжээ, зохион байгуулах ажлыг төлөвлөж, тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах, эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, ур чадварыг тогтмол дээшлүүлэх зорилготой.

Гурав. МАГАДЛАН ХЭЛЭЛЦЭХ ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

3.1. Эрүүл мэндийн байгууллага бүр (ор бүхий улсын болон хувийн хэвшлийн) эмнэлгийн нөхцөлд эндсэн 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийн тохиолдлыг эмгэг судлалын шинжилгээний дүгнэлт гарснаар эмнэлзүйн хурлыг (дээд шатны байгууллагатай зөвшилцөн, холбогдох мэргэжилтний төлөөллийг оролцуулан) тухай бүрт хийж, материалыг эрүүл мэндийн газарт ажлын 7 хоногийн дотор цаасан болон цахим хэлбэрээр илгээнэ.

3.2. Эрүүл мэндийн байгууллага бүр 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийн тохиолдлыг магадлан хэлэлцэх зөвлөлийн хурлыг улиралд 1 удаа хийнэ.

3.3. Төр болон хувийн хэвшлийн анхан шатны Эрүүл мэндийн байгууллага (өрх, сумын эрүүл мэндийн төв, хувийн хэвшлийн эмнэлэг)-д эндсэн 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийн тохиолдлыг Эрүүл мэндийн газарт магадлан хэлэлцэнэ.

3.4. Бүсийн оношилгоо эмчилгээний төв (БОЭТ) нь 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийн тохиолдол бүрийг байгууллага дээрээ магадлан хэлэлцэнэ.

3.5. Зөвлөлийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэнэ.

- Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийн шалтгааныг магадлан хэлэлцэж, дүгнэлт гаргана.
- Нөлөөлсөн хожимдлыг тодорхойлж, үзүүлсэн тусламж, үйлчилгээний чанарт үнэлэлт, дүгнэлт өгч, эндсэн 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийг бууруулах талаар шийдвэр гаргана.

- Оношилгоо, эмчилгээтэй холбоотой сургамж, дүгнэлт хийж, зөвлөмж гаргана.
- Дүгнэлтэд үндэслэн асуудлыг хэрхэн шийдвэрлэх арга замыг тогтоож, цаашид зохион байгуулах ажлыг төлөвлөнө.
- Өмнөх хурлаас гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг үнэлнэ.

3.6. Магадлан хэлэлцэх зөвлөлийн хуралд бүрдүүлэх материаллууд:

- Хүүхдийн өвчний түүх
- Төрөлтийн түүх /Нярайн түүх
- Эхийн жирэмсний хяналтын карт
- 5 хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр
- Нярайн эргэлтийн бүртгэл, журнал (ӨЭ-3А, ӨЭ-3Б)
- ХӨЦМ-ийн үзлэгийн маягт
- Яаралтай тусламжийн хуудас
- Эрэмбэлэн, ангилалтын үзлэгийн маягт
- Эмнэлгийн тусламж үйлчилгээ авч байсан бол тухай бүрийн холбогдох материаллууд (өвчний түүх, хийгдсэн шинжилгээнүүд) -ын хуулбар

3.7. Эрүүл мэндийн байгууллага бүр 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийн тохиолдлыг магадлан хэлэлцсэн хурлын тэмдэглэл, зөвлөмж, шийдвэрийг хурлаас хойш ажлын 7 хоногийн дотор Эрүүл мэндийн газарт хүргүүлнэ.

3.8. Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, төр болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн нөхцөлд эндсэн 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийг магадлан хэлэлцсэн хурлын шийдвэрт дүн шинжилгээ хийж, шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавин, хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийг бууруулах талаар мэргэжил аргагүйн дэмжлэг үзүүлж, гарсан дүгнэлт, шийдвэрийг 2 хувиан ЭМЯ-ны Хүүхэд судлалын мэргэжлийн салбар зөвлөл, ЭХЭМҮТ-ийн Тандалт судалгааны албанд улирал тутам албан бичгийн хамт хүргүүлнэ.

Эрүүл мэндийн газрын даргын
2023 оны 03 дугаар сарын 14-ны
өдрийн 117 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт



МАГАДЛАН ХЭЛЭЛЦЭХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ


Нэг. Аймгийн хэмжээнд эмнэлгийн нөхцөлд эндсэн 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийг магадлан хэлэлцэх зөвлөлийн бүрэлдэхүүн

Зөвлөлийн дарга:	Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	ЭМГ-ын Хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн (хүүхдийн эндэгдэл хэлэлцэх үед) ЭМГ-ын Эх барих, эмэгтэйчүүдийн асуудал хариуцсан мэргэжилтэн (нярайн эрт үеийн эндэгдэл, амьгүй төрөлт хэлэлцэх үед)
Гишүүд:	ЭМГ-ын Анхан шатны тусламж хариуцсан мэргэжилтэн ЭМГ-ын Эмнэлгийн чанар, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн БОЭТ-ийн Хүүхэд, нярайн зөвлөх эмч БОЭТ-ийн Эх барих, эмэгтэйчүүдийн зөвлөх эмч ЭМГ-ын Сувилахуйн тусламж хариуцсан мэргэжилтэн ЭМГ-ын Статистикч эмч, мэргэжилтэн Шаардлагатай тохиолдолд бусад холбогдох эмч, мэргэжилтэн (Удирдлага төлөвлөлтийн хэлтэс, Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга нар, мэргэжилтнүүд) БОЭТ-ийн анатомийн эмгэг судлаач эмч

Хоёр. Магадлан хэлэлцэх зөвлөлийн бүрэлдэхүүний гүйцэтгэх үүрэг

- 2.1 Зөвлөлийн дарга эндэгдлийн хурлыг удирдан зохион байгуулах, бэлтгэл ажил, шийдвэрт хяналт тавина.
- 2.2 Хурлыг зөвлөлийн дарга удирдан явуулна.
- 2.3 Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь харьяа эрүүл мэндийн байгууллагаас хурлын тэмдэглэл, шийдвэрийг хүлээн авч, зөвлөлийн гишүүдэд урьдчилан танилцуулж, хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг гарган, зөвлөлийн даргаар батлуулан танилцуулна. Хурал зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах ба холбогдох байгууллагад мэдээ тайлан хүргүүлнэ.

- 2.4 Зөвлөлийн гишүүд ирүүлсэн материаллуудтай бүрэн танилцаж, өөрийн хариуцсан ажлын чиглэлээр үнэлэлт, дүгнэлт өгч, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны зөвлөмжид санал өгөх, өмнөх хурлын шийдвэрийг биелүүлэх, хэрэгжилтийг хангаж, тайлагнана. Оролцох боломжгүй үед саналаа бичгээр ирүүлнэ.
- 2.5 Эрүүл мэндийн байгууллагын мэдээ, тайлан хариуцсан мэргэжилтэн нь бүртгэл, мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавьж ажиллана.
- 2.6 Асуудлыг хурлын төлөвлөгөөний дагуу танилцуулга, асуулт хариулт, санал дүгнэлт, шийдвэр гэсэн дарааллаар хэлэлцэнэ.
- 2.7 Хэрэв тусламж үйлчилгээний ноцтой алдаа, зөрчил гарсан гэж үзсэн тохиолдолд эрүүл мэндийн байгууллагын холбогдох удирдлага, эмч нарыг оролцуулан өргөтгөсөн хэлбэрээр зохион байгуулна.
- 2.8 Хурлын тэмдэглэлийг зөвлөлийн нарийн бичгийн дарга хөтлөх бөгөөд хурал удирдагч, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.
- 2.9 Хурлын тэмдэглэлд дор дурдсан зүйлс зайлшгүй тусгагдсан байна.
- Ирцийн байдал (Зөвлөлийн гишүүдийн тоо, хувь, хуралд оролцсон хүмүүсийн овог, нэр, албан тушаал)
 - Хурлын явц, эхэлсэн, дууссан цаг
 - Хурлын дүгнэлт, шийдвэр, сургамж
- 2.10 Хурлын шийдвэрийг баримтжуулан, холбогдох эрүүл мэндийн байгууллагад зөвлөмж өгч, мэргэжил аргагүйгээр ханган, гүйцэтгэлийн хяналт тавина.



5 ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХДИЙН ЦОГЦСЫГ ЭМГЭГ СУДЛАЛЫН ШИНЖИЛГЭЭНД ОРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг мэдээлэх

- 1.1 Эрүүл мэндийн газрын статистик эмч нь эмнэлэгт нас барсан 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн тохиолдолд бүрийг 7 хоногийн Мягмар гараг бүрт ЭХЭМҮТ-ийн Тандалт судалгааны албанд, ЭМХТ-д сар бүрийн 2-3-нд мэдээлнэ.
- 1.2 Эмнэлгийн болон эмнэлгийн бус нөхцөлд эндсэн 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн тохиолдолд түргэн тусламжийн төвийн дуудлагаар очсон буюу анх мэдсэн эмч хүүхдийн эндэгдлийн тохиолдол бүрийг байгууллагын удирдлагад мэдээлж, тухайн байгууллага 24 цагийн дотор Эрүүл мэндийн газрын хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн, статистик эмчид мэдэгдэнэ.
- 1.3 Эрүүл мэндийн газрын хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн, статистик эмч, эмнэлгийн болон эмнэлгийн бус нөхцөлд эндсэн 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн тохиолдлыг 7 хоногийн Мягмар гараг бүрт ЭХЭМҮТ-ийн Тандалт судалгааны албанд, ЭМХТөвд сар бүрийн 2-3-нд мэдээлнэ.

Хоёр. Эмгэг судлалын шинжилгээнд оруулах

- 2.1 Эмнэлэгт эндсэн 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн цогцост анатомийн эмгэг судлаач эмч, үхлийн шалтгаан болон өвчний онош зөв тогтоосон эсэхийг тодорхойлох зорилгоор эмгэг судлалын шинжилгээг хийнэ.
- 2.2 Эмнэлэгт нас барсан 5 хүртэлх насны хүүхдийн цогцосыг нас барснаас хойш 24 цагийн дотор, дараа өдрийн 12 цагаас өмнө эмгэг судлалын шинжилгээг хийнэ.
- 2.3 Эмнэлгийн бус нөхцөлд эндсэн 5 хүртэлх насны хүүхдийн цогцост эмгэг судлалын зайлшгүй хийх шаардлагатай шинжилгээг 2017 оны ЭМС-ын А/55 дугаар тушаалын заалтаар зохицуулан БОЭТ-ийн анатомийн эмгэг судлаач эмч хийнэ.

Гурав. Эмнэлзүй-эмгэг судлалын бага хурал хийх

- 3.1 Эмгэг судлалын эцсийн онош, дүгнэлт гарснаас хойш ажлын 7 хоногийн дотор байгууллагад суурилсан эмнэлзүйн хурлыг эрүүл мэндийн газраас холбогдох төлөөлөл, анатомийн эмгэг судлаач эмчийг оролцуулан зохион байгуулна.
- 3.2 Эмнэлзүйн хурлаар 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгаан, үзүүлсэн тусламж үйлчилгээний чанарт нэлэлт дүгнэлт өгч цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал зөвлөмж гаргана.
- 3.3 Хурлын шийдвэр холбогдох материалыг Эрүүл мэндийн газрын магадлан хэлэлцэх зөвлөлд хурлаас хойш 7 хоногийн дотор хүргүүлнэ.

- 3.4. Хурлаар хэлэлцэх асуудлууд:
- 3.4.1 Үндсэн оношийн зөрүүтэй бүх тохиолдлууд
- 3.4.2 Эмчилгээ үйлчилгээний дутагдал, ноцтой тохиолдол, хожимдол-3 гэж тодорхойлсон бүх тохиолдлууд
- 3.4.3 Эмгэг судлалын шинжилгээгээр онош бүрэн тавигдаагүй тохиолдлууд
- 3.4.4 Сургалтын болон эмчилгээний холбогдолтой ховор тохиолдлууд

--oOo--